



ДАРХАН УУЛ АЙМАГ
ХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГА

45025 Хонгор сум, Дархан-Уул аймаг
Цахим шуудан: khongorsum9@gmail.com

᠔᠐᠕5.01.᠒8 № 1/᠖᠗
танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМАНД

Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт шохойн чулууны үйл ажиллагаа явуулдаг “Сутайн үхэр чулуут” ХХК-ний барилгын шохойн үйлдвэрийн өргөтгөл шинэчлэлийн төсөл нь 2024 онд үйл ажиллагаа явуулаагүй болно.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБААТАР

Банк хооронд



Гүйлгээ амжилттай хийгдлээ.



Гүйлгээний огноо
2025-04-16 11:50



Журнал дугаар
923790630790



Шилжүүлэх данс
MN570034104200148741



Банк
Төрийн сан



Дансны дугаар
MN070090100190255402



Хүлээн авагчийн нэр
Да.Хонгор Байгаль НСБарьцаа



Дүн
4,500,000.00 MNT



Гүйлгээний утга
Сутай Үхэр чулуут ХХК 4265831
барьцаа



Гүйлгээний зориулалт
Бусад төлбөр

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ХАНДСҮРЭН

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“СУТАЙН ҮХЭР ЧУЛУУТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Д.ГАНБАТ

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ
БУЙ “БАРИЛГЫН ШОХОЙН ҮЙЛДВЭРИЙН ӨРГӨТГӨЛ,
ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 4265831

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ИЙН ШИНЖЭЭЧ

БОЛОВСРУУЛСАН:

“СУТАЙН ҮХЭР ЧУЛУУТ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

О.АЗЗАЯА

2024 он

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	7
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	9
4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..	16
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	19
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	22

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн эргэлтийн цэгийн солбилцлууд.....	4
Хүснэгт 2. Төслийн барилга байгууламж	6
Хүснэгт 3. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа	11
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	16
Хүснэгт 6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	19
Хүснэгт 9. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.	21
Хүснэгт 10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө	22

Зургийн жагсаалт


Зураг 1. Төслийн байршлын зураг.....	3
Зураг 2. Төслийн талбай /дроны зураг/	4
Зураг 3. Цех.....	4
Зураг 4. Шохой шатаах машин суурьлуулсан байдал.....	4
Зураг 5. Эргэх зуух.....	5
Зураг 6. Бүхэл шохойн тээрэм.....	5
Зураг 7. Нунтаг шохойн сылос.....	5
Зураг 8. Материал зөөх дугуйт ачигч	5
Зураг 9. Барилга байгууламж	5

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Барилгын шохойн үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлт”

Төсөл хэрэгжүүлэгч: “Сутайн үхэр чулуут” ХХК /улсын бүртгэлийн дугаар: 1911017149, регистрийн дугаар: 4265831, албан ёсны хаяг: Дархан-Уул, Дархан, 5-р баг, Их цагаан туг ХХК, утас: 99520006/

Төслийн байршил: “Сутайн үхэр чулуут” ХХК-ийн Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Барилгын шохойн үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлт” төсөл нь Дархан-Уул аймгийн төвөөс Шарын гол сум руу явах зам дагуу байрлана. Улаанбаатар хотоос 231 км-т, Дархан-Уул аймгийн төвөөс 6 км-т, Хонгор сумын төвөөс 15 км-т байрлана. Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1 дүгээр багт байрлах “Шохой шатаах, эргэх зуухан цех” төслийн талбайг Хонгор сумын засаг даргын захирамжаар 2004 оны 09 сарын 19-ны өдрийн 43 тоот шийдвэрийг үндэслэн 0002309 дугаартай газрын гэрчилгээтэй 28 га талбайг “Шибя” ХХК шохойн ордын зориулалтаар эзэмшдэг. Тус газрын 1 га талбайг 2018 оны 01 дугаар сарын 02-ны өдөр Г-01/2018 дугаар бүхий түрээсийн гэрээг 5 жилийн хугацаатай “Сутай үхэр чулуут” ХХК-тай байгуулсан байна.



Зураг 1. Төслийн байршлын зураг

Хүснэгт 1. Төслийн талбайн эргэлтийн цэгийн солбилцлууд

№	X	Y
1	5476923.997	575568.239
2	547626.467	575556.885
3	5476916.663	575537.091
4	5476924.511	575523.196
5	5476956.059	545502.381
6	5476975.998	575517.198
7	5476952.346	575574.059
8	5476997.321	575643.121
9	5476969.413	575689.562
10	5476951.883	575678.723
11	5476954.911	575666.186
12	5476865.537	575623.588
13	5476894.840	575584.146



Зураг 2. Төслийн талбай /дроны зураг/



Зураг 3. Цех



Зураг 4. Шохой шатаах машин суурьлуулсан байдал

Тоног төхөөрөмжүүд



Зураг 5. Эргэх зуух



Зураг 6. Бүхэл шохойн тээрэм



Зураг 7. Нунтаг шохойн сылос



Зураг 8. Материал зөөх дугуйт ачигч

Дэд бүтэц

Барилга байгууламж

Үйлдвэрийн барилга байгууламжид үйлдвэрийн байр, оффисын байр, ажилчдын душ болон хоолны байр, агуулах-засварын байр зэрэг багтана.



Зураг 9. Барилга байгууламж

Хүснэгт 2. Төслийн барилга байгууламж

1	Засвар механикийн хэсэг	50м ²
2	Шатаах үйлдвэр	200 м ²
3	Сэлбэг, материалын агуулах	20 м ²
4	Харуул хамгаалалтын байр	20 м ²
5	Оффис	40 м ²
6	Түүхий эдийн талбай	500 м ²
7	Бэлэн бүтэгдэхүүний талбай	500 м ²
8	Гал тогоо, Душ	60 м ²

Машин техник, тоног төхөөрөмжийн завсар үйлчилгээ: Үйлдвэрийн дэргэд жижиг засварын газрыг барьж байгуулна. Үйлдвэрийн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна. Төв суурин газарт байрлаж байгаа тул томоохон хэмжээний засвар үйлчилгээгээр орон нутгийн засвар үйлчилгээний газраас гэрээгээр гүйцэтгүүлнэ.

Шатах тослох материалын агуулах: Үйлдвэрийн байршил нь төв суурин газарт байрлалтай учир шатах, тослох материалыг хадгалах зориулалтын сав шаардлагагүй бөгөөд хаягдал маслыг хадгалах хэсэг гаргах бөгөөд ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

Цахилгаан хангамж: “ДСЦТС” ХХК-тай 2018 оны 10 сарын 17 өдөр Цахилгаан Эрчим Хүчээр хангах гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. “Сутайн үхэр чулуут” ХХК-ийн шохой шатаах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг дараах байдлаар ангилж хуваалаа.

- Шохой шатаах үйлдвэр
- Оффис
- Душ
- Гал тогоо
- Засвар механикийн хэсэг
- Харуул хамгаалалтын байр

Үйлдвэрийн хувьд дээр дурдсан бүх хэрэглэгчдийг 0.4кВ-ын цахилгаан эрчим хүчээр тэжээх 10/0.4 кВ-ын нэг хүчний трансформатор бүхий 630 кВА-н дэд станцаас тэжээнэ.

Усан хангамж: Усны эх үүсвэр: Үйлдвэрийн нийт усны хэрэглээг одоо гаргасан байгаа гүний худгаас хангахаар тусгаж өгсөн. Жилд зарцуулах цэвэр усны хэмжээ дунджаар 4.75 мян.м³ шаардлагатай буюу 0.3 л/с ундаргатай Идэрхайрхан ХХК-ний гүний худгаас үйлдвэрийн нийт хэрэглээг бүрэн хангахаар байна.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уул зүй: Хонгор сум нь Хангай, ойт хээрийн бүст Хараа, Ерөө голын сав газарт далайн төвшнөөс дээш 700-1000 метрт өргөгдсөн, цаг уурын эрс тэс уур амьсгалтай. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Уул нурууд нь хойноос урагш уртраг дагасан байрлалтай байна. Сумын нутаг дэвсгэр нь уул, ой хээр, уул мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой. Төсөл хэрэгжих Дархан-Уул аймаг нь байгалийн бүс бүслүүрээр ойт хээрийн болон хээрийн бүсэд хамаарах бөгөөд “Шохой шатаах эргэх зуухан цех” төслийн талбай нь байгалийн бүс бүслүүрээр ойт хээрийн бүсэд хамаарч байна. Гэвч төсөл хэрэгжих талбайд ойн зурвас газар байхгүй болно. Уулын энгэрт байрлаж байна.

Цаг агаар, хур тунадас: Байгалийн эрс тэс уур амьсгалтай, жилийн 4 улирлын ялгаа ихтэй, агаарын температурын хэлбэлзэл их, хур тунадасны хэмжээ, чийг багатай цаг агаарын нөхцөлтэй. Тус аймаг нь уур амьсгалын мужлалын хувьд ширүүвтэр өвөлтэй, дулаан зунтай, чийгээр дутмаг мужид багтана. Хонгор сум орчмын нутгаар сүүлийн 30 жилийн хугацаанд агаарын температурын жилийн дундаж -1.9 градус хүйтнээс +3.2 градус дулаан байдаг байна. 1984-1988, 1991, 1996, 2005, 2010, 2012 онуудад агаарын температурын жилийн дундаж утга хасах градустай, бусад онуудад нэмэх градустай байдаг.

Агаарын температурын УАД-нь 0.7 градус дулаан, хамгийн их нь 1999 онд 44.5 градус /Хонгор суманд 7 сард / хүрч халсан, хамгийн бага нь 2001 онд -48.5 градус /Хонгор суманд 1 сард / хүрч хүйтэрсэн байна. Жилд дунджаар 220-230 өдөр хүйтрэлтэй байж бусад хугацаанд дулаан байдаг.

Ус зүй: Монгол орны гадаргын усны Хойд мөсөн далайн ай савын Хараа голын ай савд хамаарна. Далайн төвшнөөс дээш 700-1000 метрт өргөгдсөн. Хэнтий нуруунаас эх авч урссан том, жижиг голууд бүрдэл нь Хараа голд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Дархан Уул аймгийн усаар бүрхэгдсэн нийт талбай 2112.54 га. Үүнээс гол горхи 1998.0 га, нуур цөөрөм 24.0 га, үйлдвэрийн болон аж ахуйн зориулалтын усан сангийн талбай 1.0 га тус тус эзэлдэг. Гадаргын усны бүртгэл тооллогоор уст цэг 956, нуур цөөрөм 3, гол горхи 31, булаг шанд 26, худаг 878 бүртгэгджээ.

Хөрс, ургамлын бүрхэвч, амьтны аймаг: Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өргөргийн бүсшилийн Орхон-Шаамарын тойрогт хамрагдана. Төслийн талбайн ойр орчимд хар хүрэн хөрс тархсан байна. Хар хүрэн хөрс уулс хоорондох өргөн, нарийн хөндийн гүвээрхэг болон тэгшивтэр хэсгээр голлон тогтворжих бөгөөд ургамлан нөмрөгт тал хээрийн ургамал болох хялгана-алаг өвст бүлгэмдэл давамгайлна. Мөн тухайн

хөрс үржил шимийн түвшин өндөртэй байна. Хар хүрэн хөрс бүхий газар бараг нэлэнхүйдээ газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглагддаг.

Нутгийн иргэдийн хувьд газар тариалан, бэлчээрийн чиглэлээр газар ашиглалт явуулдаг учир бэлчээрийн ургамал зонхилно. Бэлчээрийн тусгаг бүрхэцэд хамгийн олон тааралдах зүйл нь ширэг улалж байгаа ба нийт ургамлан бүрхэвчийн 30 орчим хувийг эзэлж байна. Үүний дараагаар хялгана, ишгүй гичгэнэ, дэрвээн хазаар өвс, агь зэрэг юм. Мөн хагд өвс, дэлхээ тогторгоно, бяцхан навчит болон нарийн навчит харгана тааралдана. Дархан сумын төвийн ойролцоох бэлчээрт ширэг улалж, бяцхан навчит болон нарийн навчит харгана, ишгүй болон имт гичгэнэ, агь шарилж ихээр ургаж бэлчээр доройтож малын шим тэжээлт ургамлууд ховордсон байна. Шарын гол сумын нутгаар хялгана, ширэг улалж, хиаг, гандбадраа, дэрвээн хазаар өвс, ерхөг, шарилж, биелэг зэрэг ургамал ургаж Дархан уул, Олон хөтлийн орчим малчид ихээр зусаж, мал бэлчээрлэлтийн даац хэтэрсэнээс ургамал малд нилээд идэгдсэн 5.5-8.1цн, Санжинт багийн Буянт орчмоор га-гаас 9-10 цн ургацтай байгаа юм. Ер нь Дархан, Шарын гол сумын нутагт мал бэлчээрлэх газар нутаг багатай тул зэргэлдээ сумдын нутагт орж зусдаг.

Монгол орны амьтны аймгийн газар зүйн хуваарилалтаар уулархаг Азийн дэд их муж, Монгол төвдийн мужийн Монгол дагуурын тойрогт хамрагдана. Аймгийн нутагт 400 орчим зүйлийн шувуу, 4 зүйлийн гүрвэл, хоёр нутагтан, 50 гаруй зүйлийн загас, 5 зүйлийн туурайтан, 30 гаруй зүйлийн мэрэгчид, 10 гаруй зүйлийн махан идэштэн, 2 зүйлийн гар далавчтан 12 зүйлийн нялцгай биетэн, 12000 зүйлийн шавьж багтдаг гэсэн тоо баримт байдаг

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Дархан-Уул аймгийн Хонгор сум нь Буурал, Зулзага, Салхит гэсэн 3 багийн нийт 1529 өрхөд 5694 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Дархан-Уул аймгийн 4 сумаас 3-т, аймгийн газар нутгийн 77 хувийг эзлэн оршдог, хүн амын нягтрал нь 46.35 хүн/га. Сумын газар нутаг дээгүүр ОХУ-ыг Нийслэлтэй холбосон улсын чанартай 34 км авто зам дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогддог бөгөөд 2021 онд Салхит багийг сумын төвтэй холбодог замыг хатуу хучилттай болгосон байна. Монголын газар тариалангийн төв бүсэд оршдог учраас хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнд газар тариалан голлодог бөгөөд газар тариалангийн аж ахуйнууд шинжлэх ухааны баазтайгаа ойрхон байрлаж, түүнтэй хамтран ажилладгаараа бусад аймгуудаас давуутай юм. Аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь хүн амын мах махан бүтээгдэхүүний хэрэгцээний 30%, сүү сүүн бүтээгдэхүүний 90%, гурил гурилан бүтээгдэхүүний 70% гаруй хувийг, төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа стратегийн ач холбогдол бүхий салбарын нэг юм.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл: Үйлдвэрийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис, тоос тоосонцор нь шохой шатаах үед шатаах зуухны яндан болон бүтээгдэхүүн тээвэрлэх явцад илэрнэ. Үйлдвэрээс үүсэх тоосны дийлэнх хэсэг нь шатаах зуухнаас гарах бөгөөд дараах үйл ажиллагаа нь тоосны эх үүсвэр болно. Үүнд:

- Бүтээгдэхүүн ачих, буулгах үед үүсэх тоосжилт
- Түүхий эдийг зөөх, тээвэрлэх
- Бутлах цех
- Зуухны яндан
- Агаар сорох систем
- Шатаах зуух
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Хөрс, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж, буулгах үед хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх
- Барилгын ажлын үед үүсэх барилгын хог хаягдалд ургамлан нөмрөг талхлагдах
- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор ургамлан нөмрөг талхлагдах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Дуу чимээний үзүүлэх нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагаа эхэлснээр үүсэх дуу чимээ нь ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх
- Нутгийн оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах
- Амьтдад ойр орчмоос дайжих

4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд 9.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах аргазүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Хүснэгт 3. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	3.5
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	0.5
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2.5
6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.5
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	0.75
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	0.25
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		9.0

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Сутайн үхэр чулуут” ХХК-ийн “Шохой шатаах эргэх зуухан цех”-ын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг нэгтгэж доорх хүснэгтэд тусгалаа.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
1. АГААРЫН ЧАНАР									
1	Төсөл хэрэгжих талбайд олон тооны том оврын машин зорчих ба тэдгээрээс агаарт их хэмжээний тоосжилт үүсэх	Төсөл хэрэгжих талбайн автомашины зогсоол болон автозамын хэсгүүдэд хуурайшилттай үеүдэд усалгаа хийх	Төслийн талбай	-	-	-	0.5	2025 онд	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль; Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008 Бензин хөдөлгүүртэй авто машин- Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009
2		Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах болон салхинаас хамгаалах зорилгоор мод бут тарих	Төслийн талбай	-	-	-	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд тусгасан	2025 онд	

3	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тусгайлан бэлдсэн цэгт хаяагүй, тогтсон хугацаанд ачуулж, ариутгал хийгдээгүйгээс орчны агаар бохирдох	-Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях зохих шаардлага хангасан битүүмжлэлтэй, хог хаягдлыг ангилан ялгах боломжтой хогийн сав байрлуулах -Сумын ТҮК-тэй гэрээ байгуулан тогтмол хугацаанд хогоо ачуулах - Хогийн цэгийг тогтмол хугацаанд хлорминаар ариутгах	Төслийн явцад	-	-	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	2025 онд	Дизель хөдөлгүүртэй авто машин- Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
4	Төслийн үйл ажиллагаанд ашигладаг тээврийн хэрэгслүүдээс агаар орчин бохирдох	Тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг, оношлогоонд хамруулж, утаанд хяналт тавьж ажиллах, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төслийн явцад	-	-	-	1.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ									
5	Автомашин хөдөлгөөн зэргээс хөрс элэгдэл, эвдрэл үүсэхээс гадна	Ажилчдын байрны гадна талбайд олон наст ургамал тариалах	Төслийн талбай	-	-	-	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд тусгасан	2025 онд	Газрын тухай хуулийн 50-р зүйл 50.1.1 дэх заалт. MNS 5917:2008 Уул уурхайн
6	хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй.	Төсөл хэрэгжих талбай, түүний орчимд хог хаягдал хаяхгүй байх, төслийн талбайн гадна газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх	Төслийн талбай	-	-	-	0.5	Төсөл хэрэгжих хугацаанд	үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага

7		Нефтийн бүтээгдэхүүн битүүмжлэлийг сайтар шалгаж ажиллах, хэрэв асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Төслийн талбай	-	-	-	1.0	Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
8		Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх	Төслийн талбай	-	-	-	0.5	2025 онд	
3. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ									
9	Усны нөөц багасах, түвшин буурах	Усыг ариг гамтай ашиглах	Төслийн явцад	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	Усны тухай хууль, “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.
10		Бусад шаардлагагүй тохиолдолд гадаргын хэлбэр, төрх байдлыг өөрчлөхгүй байх	Төслийн явцад	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	
11		Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа голоос дээж авч шинжилгээ хийлгэж, усны найрлагыг тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг хянаж байх	Төслийн явцад	-	-	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	2025 онд	
4. АМЬТНЫ АЙМАГ									

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт байрлах “Барилгын шохойн үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлт” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

12	Хог хаягдлыг амьтанд хоргүйгээр шийдвэрлэх	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Хог хаягдлын хүрээнд	-	-	-	Хог хаягдлын мененжментийн зардалд	2025 онд	Хог хаягдлын тухай хууль 2017 он Амьтны тухай хууль 2012 он
13	Амьтанд гэмтэл учруулах, тоо толгой хорогдох	Ажилчдыг байгаль орчныг хамгаалах, ан амьтдад хохирол учруулахгүй байх талаар сургалт зохион байгуулах	Төсөл хэрэгжих хугацаанд	-	-	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан	2025 онд	
Нийт сая.төг			3.5 сая.төг						

6.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ажилчдын байрны ойролцоо мод тарих, арчилгаа тордолгоо хийх	ш	20	-	0.5	2025 онд	MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
Нийт дүн, сая.төг		0.5					

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2025 оны БОМТ-д нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй байна. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал сая.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ажилчдын хариуцлагагүй байд, цаг агаараас үүдэлтэй осол, эрсдэл үүсэх	Байгаль орчныг хамгаалах, галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Төсөл хэрэгжих үед	-	-	0.5	2025 онд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2	Үйлдвэрийн осол эрсдэл үүсэх	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	Төсөл хэрэгжих үед	-	-	0.5	2025 онд	
3	Гал түймрийн аюул болзошгүй эрсдэл	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох / Гал унтраах багаж хэрэгсэл, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт /	Төслийн ажилчдын хүрээнд	-	-	0.5	2025 онд	
4	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Төсөл хэрэгжих үед	-	-	1.0	2025 онд	
Нийт зардал (сая.төг)				2.5 сая.төг				

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдалын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах	Төслийн талбайн бүх барилга байгууламжуудад	-	-	-	0.5	2025 он	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;
2		Хог хаягдлын түр хадгалах цэгийг ангилан ялгах, битүү тагтай, хог хаягдал салхиар хийсч тарахааргүй байхаар сайжруулах	Төслийн талбайд	-	-	-	0.5	2025 он	
3	Шингэн	Гал тогоо, хог хаягдлын цэг, 00-ийн ариутгал халдваргүйжүүлэлт	Төслийн талбайд	-	-	-	0.5	Сард 1 удаа	
	Нийт мян.төг		1.5 сая.төг						

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (сая.төг)	Нийт зардал (сая.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Хөрсний бохирдол								
1	Хөрсний химийн шинж чанар, механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 1 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	-	0.25	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. (2008). Монгол улсын стандарт - MNS 5850:2008. Улаанбаатар.
2	Хүнд металлын агууламж	Хөрс түлш, шатах тослох материалаар бохирдох	Төслийн талбайд 1 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	-	0.25	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга. (1991). Монгол улсын стандарт - MNS 3310:1991. Улаанбаатар.
3	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ хийлгэх	Төслийн талбайн хог хаягдал, шингэн хог хаягдалаар бохирдох	Төслийн талбайд 1 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	-	0.25	Хөрсний чанар. Хөрсөнд эрүүлзүйн нян судлалын шинжилгээ хийх арга. (2012) MNS 6341:2012. Улаанбаатар. Хөрс. Гэдэсний бүлгийн нян ,гэдэсний бүлгийн халуун даадаг нян болон байж болох E.Coli-г илрүүлэх арга. (2004) MNS 5367:2004. УлаанбаатарMNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2. Усны хяналт шинжилгээ								

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт байрлах “Барилгын шохойн үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлт” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбайд	Унд ахуйн ус хангаж буй гүний худгаас	2025 он	Жилд 1 удаа	-	0.25	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Нийт зардал сая.төг					0.75 сая.төг			

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг сая.төг	Зардал сая.төг	Хугацаа
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод зохион байгуулалтаар		2025 он
2	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 11 сард
3	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Төсөл хэрэгжих хугацаанд	0.25		2025 он
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				0.25 сая.төг	

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн дүүргийн иргэдийн хуралд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийж байх шаардлагатай болно.

Хүснэгт 10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Дархан-Уул аймгийн Байгаль орчны газарт	Цахимаар	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хянуулах	2025.он	Дотоор төлөвлөлтөөр	“Сутайн үхэр чулуут” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн	Дархан-Уул аймаг
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Цахимаар					Цахимаар
Нийт		-				